

## Хөгжимийн ордны гоцлол дуучид Монгол улсад анх удаа тоглолт хийж

11 дүгээр сарын 20-ны өдөр баасан гарагт 17:00 цагт Санкт-Петербург хотын Хөгжимийн ордон болон «Россотрудничество» нь Монгол улсад болох “Ур чадварын төлөөлөгчдийн” тоглолтод урьж байна. Улаанбаатар хот дахь ОХУ-ын шинжлэх ухаан, соёлын төвд олон улсын улсын тэмцээний ялагч Александр Петров (лимбэ), Александр Кашпурин (төгөлдөр хуур) нар тоглолтоо хийнэ.

Энэ үдэш үзэгчдийг хөгжимийн маш олон төрлийн урсгал хүлээж байна. Үүнд: романтикудаас ХХ зуун хүрлэх багтах болно. Шубертийн уран сайхны хөмрөгөөс “Хатсан цэцэгс”, “Гайхалтай тээрэмчин бүсгүй”, Шопены төгөлдөр хуурын хэсэгчилсэн ая гэх мэт романтик үеийн хөгжим эгшиглэнэ. ХХ зууны хөгжимийн тухайд Прокофьев-ийн гуравдугаар сонат “Хуучин дэвтрүүдээс”, Скрябин-ы Сонат, мөн Гүржийн алдарт зохиолч Отар Тактакшвили-гийн лимбэ, төгөлдөр хуурын ари. ОХУ-ыг төлөөлж Николай Платонов “Улаан сарафан” тоглоно. Петр Чайковский-гийн 175 жилийн ойд зориулан түүний “Евгений Онегийн болон “Сентиментальный вальс” дуурийн “Ленский-гийн арийг тоглох болно.

**Александр Петров** (22 настай). Ленинградская мужийн, Луга хотод төрсөн. Петербургийн хөгжмийн дээдийн оюутан (ОХУ-ын гавьяат жүжигчин, профессор Ольга Чернядьева-ийн анги). "Мөнгөн камертон" (2009 он) олон улсын уралдааны болон "Европт хүргэх цонх" олон улсын наадам, уралдааны ялагч. 2012 оноос хойш Хөгжмийн ордон хөтөлбөрийн оролцогч.

**Александр Кашпурин** (18 лет). Волжск хот, Волгоград мужид төрсөн. Петербургийн хөгжмийн дээдийн оюутан (ОХУ-ын гавьяат жүжигчин, профессор Татьяна Загоровская-ийн анги). Бүх Оросын "Оросын залуу авьяастан" тэмцээний ялагч (Москва хот 2011 он), Олон улсын "Орчин үеийн сонгодог урлагийн" тэмцээний ялагч (Латви улс 2012 он), и Олон улсын «Chopin Golden Ring» тэмцээний ялагч (Словени улс, 2013). 2013 оноос хойш Хөгжмийн ордон хөтөлбөрийн оролцогч.

### **Улаанбаатар хот дахь ОХУ-ын шинжлэх ухаан, соёлын төв**

Эхлэл 17:00

Урилагаар орно

Хаяг: Улаанбаатар хот, 12 дугаар хороолол, Токиогийн гудамж, 39 дүгээр байр

Утас: (976-11) 458682

“Ур чадварын төлөөлөгчид” төсөл нь Санкт-Петербург болон «Россотрудничество»-ийн 2012 оноос хойш явуулж байгаа өвөрмөц төсөл бөгөөд ОХУ-д тэргүүлэх хөгжимчид, уран бүтээлчдийн уулзалт зохион байгуулагддаг ба Европын холбооны улс болон ОХУ-ын шинжлэх ухаан, соёлын төвүүдээр аялан тоглолт зэрэг хийгддэг юм.

Санкт-Петербургийн Хөгжмийн ордон нь – 2006 онд байгуулагдсан соёлын байгууллага бөгөөд үүний зорилго нь оросын залуу хөгжимчдийг олон улсын тэмцээн урладаан, наадамд бэлтгэх юм. Агуу Алексей Романов вангийн Мойка 122 дээрх ордонд байрладаг болно. 2015-2016 онд Хөгжмийн ордны арав дахь жилийн ой болно.

Уран сайхны найруулагч – алдарт морин хийлч, ОХУ-ын ардын жүжигчин, профессор Сергей Ролдугин.

Дэлгэрэнгүй мэдээллийг : [www.spdm.ru](http://www.spdm.ru) хаягаар авч болно.